



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС ХХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: СНАГ-2024/38/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261665 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: С.Нацагдорж  
Утас: 260512 Цахим хаяг: [natsagdorjs@audit.gov.mn](mailto:natsagdorjs@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Эрдэнэзул  
Утас: 260512 Цахим хаяг: [erdenezulb@audit.gov.mn](mailto:erdenezulb@audit.gov.mn)

Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн захирал: М.Нурболат  
Утас: 70007275 Цахим хаяг: [lightanddelightaudit@gmail.com](mailto:lightanddelightaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ Э.УУГАНБАЯР ТАНАА

2024.03.25 № 07/814  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс алт ресурс ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Эрдэнэс алт ресурс ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,062.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээр санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал:

- Компанийн үйл ажиллагаанд ашиглахгүй байгаа 19 тээврийн хэрэгсэлд тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн зорилгоор 278.4 сая төгрөгийн элэгдэл тооцсон;
- Гэрээний үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор худалдан авсан бараа ажил үйлчилгээний чанарын баталгаа 39.8 сая төгрөгийг суутгаагүй;
- Тайлант хугацаанд 712.8 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалтад гүйцэтгэгчийг харьцуулалтын болон нээлттэй тендер сонгон шалгаруулах журмаар сонгон шалгаруулаагүй, шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 8.6, 8.7.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.5, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалд заасантай нийцэхгүй байна.

## **Асуудлыг онцолсон хэсэг**

Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор Эрдэнэс силвер ресурс ХХК-ийг Эрдэнэс алт ресурс ХХК-д нэгтгэх шийдвэр гарч, компаниудыг нэгтгэсэн байна.

Си Си Эм Икс ХХК-аас Салхит уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч байсан Жи Пи Эф ХХК-д хөрөнгө оруулалт хийсэн гэсэн үндэслэлээр Эрдэнэс силвер ресурс ХХК-аас 2022 онд 19,997.5 сая төгрөг гаргуулахаар нэхэмжилж, 2024 оны 01 дүгээр сард нэхэмжлэлийн шаардлагаа хөрөнгийн өмчлөх эрхийг тогтоолгохоор нэмэгдүүлж, шүүх хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр товлосон байна.

## **Аудитын гол асуудал**

Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрэмд охин, хараат компани, харьяа хуулийн этгээд, төслийн нэгж нь үйл ажиллагаагаа энэ дүрэм, нэгдлийн нэгдсэн стратеги төлөвлөгөө, бодлого, журамд нийцүүлэн мөрдөж ажиллах талаар тусгасан байна. Иймд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж батлах үйл ажиллагаа нь толгой компанийн эрх хэмжээний хүрээний асуудал байна.

Тайлант оны нийт орлогыг 298,207.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 146,283.9 сая төгрөгөөр, 114,842.4 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан ба хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 29,278.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 150,446.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 84,116.8 сая төгрөгийн зардал гарган, 66,330.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 5,234.9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулсан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Эрдэнэс алт ресурс ХХК-ийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 23 зорилгын хүрээнд 53 зорилтод үндэслэн нийт 202 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 195 арга хэмжээг хэрэгжүүлэн 90.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
А	Б	1	2
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>		
1.1.1	Мөнгөн хөрөнгө	513,560.13	9,772,083,046.44
1.1.2	Дансны авлага	-	675,736,896.92
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	1,522,414,509.03
1.1.4	Бусад авлага	508,623.00	201,617,853.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	69,050,000,000.00
1.1.6	Бараа материал	8,505,305.98	66,940,995,550.93
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	36,300,081.09	575,399,911.29
1.1.20	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>45,827,570.20</b>	<b>148,738,247,767.61</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,365,677,673.78	74,921,105,020.59
1.2.2	Биет бус хөрөнгө	146,213,363.26	5,036,584,937.33
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	3,421,422.90	22,461,475,182.75
1.2.8	Хойшлогдсон бондын хөрөнгө	-	853,421,554,149.69
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,515,312,459.94</b>	<b>955,840,719,290.36</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,561,140,030.14</b>	<b>1,104,578,967,057.97</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
2.1	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	254,450,091.00	4,738,722,541.58
2.1.1.2	Цалингийн өглөг	845,045.13	-
2.1.1.3	Татварын өр	14,759,562.25	95,990,165,454.88
2.1.1.4	НДШ-ийн өглөг	2,029,221.28	-
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл	1,327,359,544.00	-
2.1.1.6	Хүүний өглөг	1,145,839,708.72	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	80,286,392,321.42
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	1,926,180,248.85
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,745,283,172.38</b>	<b>182,941,460,566.73</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	3,453,167,148.20	-
2.1.2.2	Урт хугацаат нөөц (өр төлбөр)	-	2,414,595,900.00
2.1.2.4	Бондын санхүүжилтийн өглөг	-	877,333,018,853.89
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>3,453,167,148.20</b>	<b>879,747,614,753.89</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>6,198,450,320.58</b>	<b>1,062,689,075,320.62</b>
2.3	<b>ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
	Өмч		
2.3.1	Өмч: а) төрийн	100,000,000.00	101,000,000.00
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	-	28,703,725,699.86
2.3.9	Хуримтлагдсан ашиг, алдагдал	(4,737,310,290.44)	13,085,166,037.49
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>(4,637,310,290.44)</b>	<b>41,889,891,737.35</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,561,140,030.14</b>	<b>1,104,578,967,057.97</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
А	Б	1	2
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	<b>150,023,801,652.76</b>
2	Борлуулалтын өртөг	-	47,496,407,925.36
3	Нийт ашиг (алдагдал)	-	<b>102,527,393,727.40</b>
4	Түрээсийн орлого	-	236,234,319.67
5	Хүүний орлого	-	132,353,799.45
8	Бусад орлого	-	54,369,005.67
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	7,126,225,063.01
10	Ерөнхий ба удирдлагын зардал	344,379,578.59	1,789,375,139.77
11	Санхүүгийн зардал	431,501,203.74	545,843,818.70
12	Бусад зардал	15,837,725.00	1,075,207,498.26
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	-	(230,433,665.91)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	<b>(791,718,507.33)</b>	<b>92,183,265,666.54</b>
19	Орлогын татварын зардал	-	25,853,267,611.22
20	Татварын дараах ашиг (алдагдал)	<b>(791,718,507.33)</b>	<b>66,329,998,055.32</b>
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	<b>(791,718,507.33)</b>	<b>66,329,998,055.32</b>
24	Орлогын нийт дүн	<b>(791,718,507.33)</b>	<b>66,329,998,055.32</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	100,000,000.00	-	(3,945,591,783.11)	(3,845,591,783.11)
2	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	100,000,000.00	-	(3,945,591,783.11)	(3,845,591,783.11)
4	Тайлангийн үеийн цэвэр ашиг	-	-	(791,718,507.33)	(791,718,507.33)
9	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	100,000,000.00	-	(4,737,310,290.44)	(4,637,310,290.44)
10	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,328,822,732.58	1,328,822,732.58
11	Залруулсан үлдэгдэл	100,000,000.00	-	(3,408,487,557.86)	(3,308,487,557.86)
12	Тайлангийн үеийн цэвэр ашиг	-	-	66,329,998,055.32	66,329,998,055.32
14	Өмчид гарсан өөрчлөлт	1,000,000.00	28,703,725,699.86	(49,836,344,459.97)	(21,131,618,760.11)
17	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	101,000,000.00	28,703,725,699.86	13,085,166,037.49	41,889,891,737.35

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
А	Б	1	2
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	<b>109,545,958,613.34</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	80,817,630,126.91
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	2,325,600.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	285,151,101.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	-	28,440,851,785.43
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,328,157,303.60</b>	<b>65,182,379,947.44</b>
1.2.1	Ажиллагчдад олгосон мөнгө	152,788,834.53	1,816,012,847.98
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	92,666,027.04	458,290,351.46
1.2.3	Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө	5,527,140.00	15,995,626,174.97
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	4,385,600.00	2,285,172,468.67
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	5,335,061.00	3,816,693,323.14
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	5,187,725.00	1,691,683,527.42
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	28,957,694.29	37,665,722,028.25
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө		12,223,458.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,033,309,221.74	1,440,955,767.55
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,328,157,303.60)</b>	<b>44,363,578,665.90</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>3,821,422.90</b>	<b>29,383,795,562.36</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		5,287,254,669.36
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,421,422.90	46,540,893.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	24,050,000,000.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	400,000.00	-
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(3,821,422.90)</b>	<b>(29,383,795,562.36)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		-
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,345,022,044.00</b>	<b>169,031.45</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,345,022,044.00	-
3.1.4	Бусад орлого	-	169,031.45
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>17,662,500.00</b>	<b>5,208,382,648.68</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	17,662,500.00	5,065,677,793.20
3.2.5	Бусад зарлага	-	142,704,855.48
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,327,359,544.00</b>	<b>(5,208,213,617.23)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(4,619,182.50)</b>	<b>9,771,569,486.31</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>5,132,742.63</b>	<b>513,560.13</b>
<b>6</b>	<b>Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>513,560.13</b>	<b>9,772,083,046.44</b>

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны			
			Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>I. ОРЛОГЫН ҮЗҮҮЛЭЛТ</b>						
1.1	<b>Үндсэн борлуулалтын орлого</b>	<b>111,077,352.1</b>	<b>295,207,149.0</b>	<b>145,931,232.9</b>	<b>(149,275,916.1)</b>	<b>49.4</b>
1.1.1.	Исэлдсэн хүдрийн орлого	32,399,219.4			-	-
1.1.2	Баяжмалын орлого	78,678,132.7	295,207,149.0	145,931,232.9	(149,275,916.1)	49.4
1.2	<b>Бусад орлого</b>	<b>7,981,469.1</b>	<b>3,000,000.0</b>	<b>4,515,525.9</b>	<b>1,515,525.9</b>	<b>150.5</b>
1.2.1	Хүүгийн орлого	3.1		132,353.8	132,353.8	-
1.2.2	Түрээсийн орлого	842,065.4		236,234.3	236,234.3	-
1.2.3	Даатгалын нөхөн олговрын орлого	12,025.5		2,584.0	2,584.0	-
1.2.4	Алданги торгуулийн орлого	217,840.9		51,104.3	51,104.3	-
1.2.5	Цахилгааны борлуулалт	2,742,289.6	3,000,000.0	1,220,440.5	(1,779,559.5)	40.7
1.2.6	Дизель түлш борлуулалт	3,451,324.6		2,835,687.4	2,835,687.4	-
1.2.	Бараа материалын борлуулалт	715,920.0		37,121.5	37,121.5	-
	<b>НИИТ ОРЛОГО</b>	<b>119,058,821.2</b>	<b>298,207,149.0</b>	<b>150,446,758.8</b>	<b>(147,760,390.2)</b>	<b>50.5</b>
<b>II. ЗАРДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ</b>						
2.1	<b>Бүтээгдэхүүний өртөг</b>	<b>38,873,765.1</b>	<b>108,123,066.0</b>	<b>47,496,407.9</b>	<b>(60,626,658.1)</b>	<b>43.9</b>
2.1.1	Хүдрийн өртөг	4,164,932.8			-	-
2.1.2	Баяжмалын өртөг	28,002,541.7	104,623,066.0	43,443,373.9	(61,179,692.1)	41.5
2.1.3	Металлын өртөг				-	-
	Цахилгааны борлуулалт	2,742,289.6	3,000,000.0	1,220,440.5	(1,779,559.5)	40.7
	Дизель түлш борлуулалт	3,255,188.4		2,796,154.8	2,796,154.8	-
	Бараа материалын борлуулалт	708,812.6		36,438.8	36,438.8	-
2.1.4	Эрсдэлийн зардал		500,000.0		(500,000.0)	
2.5	<b>Ерөнхий ба борлуулалт удирдлагын зардал</b>	<b>26,265,292.4</b>	<b>38,160,847.0</b>	<b>10,484,774.7</b>	<b>(27,676,072.3)</b>	<b>27.5</b>
3	<b>Үйл ажиллагааны бус орлого, зарлага</b>	<b>(674,232.5)</b>	-	<b>(282,310.5)</b>	<b>(282,310.5)</b>	-
	Үндсэн хөрөнгө данснаас хассаны орлого	2,251.1			-	-
	Найдваргүй авлагын нөөц			(51,876.8)	(51,876.8)	-
	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)	(676,483.6)		(230,433.7)	(230,433.7)	-
<b>III. АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>						
4.1	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>53,245,531.2</b>	<b>151,923,236.0</b>	<b>92,183,265.7</b>	<b>(59,739,970.3)</b>	<b>60.7</b>
	ААНОАТ	16,435,643.3	37,080,809.0	25,853,267.6	(11,227,541.4)	69.7
4.2	<b>Татварын дараах цэвэр ашиг</b>	<b>36,809,887.9</b>	<b>114,842,427.0</b>	<b>66,329,998.1</b>	<b>(48,512,428.9)</b>	<b>57.8</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 5,640.1 сая төгрөгийн 11 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 5,622.6 сая төгрөгийн 10 алдааг залруулж, 17.5 сая төгрөгийн 1 алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 1,062.4 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс, 2.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 712.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 347.1 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 1,079.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 281.2 сая төгрөгөөр давсан байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант хугацаанд 6 удаагийн ажил гүйлгээгээр 29.7 сая ам.долларыг арилжаалж төгрөгт хөрвүүлэх үед гадаад валютын зарлагын гүйлгээг хэлцлийн ханшаар тооцож бүртгэлд тусгаснаас шалтгаалан 87.3 сая төгрөгийн ханшийн зөрүүний алдагдлыг бүртгээгүй байна.	1	87,279.3	1	87,279.3	-	-	1	87,279.3	-	-	-	-
1-2 жилийн насжилттай 130.4 сая, 3-аас дээш жилийн насжилттай 38.8 сая төгрөгийн авлагатай байгаа бөгөөд НБББББ-т тусгасны дагуу үүнд 51.9 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулаагүй байна.	1	51,876.8	1	51,876.8	-	-	1	51,876.8	-	-	-	-
Тайлант хугацааны эцэст Сидар ХХК-аас 400.0 сая төгрөгийн авлага, 517.4 сая төгрөгийн өглөг тайлагнасан ба тооцоог нэгтгэж хаагаагүйн улмаас авлага, өглөг тус бүр 400.0 сая төгрөгөөр тус тус илүү илэрхийлэгдсэн байна.	1	400,000.0	-	-	1	400,000.0	1	400,000.0	-	-	-	-
11-р сард Samsung C&T Corporation-д борлуулсан 641,042 кг баяжмалын өртөг болох 4,004.3 сая төгрөгийн ажил гүйлгээг дутуу бүртгэсэн байна. Үүнээс шалтгаалан татварын өмнөх ашиг 4,005.7 сая төгрөгөөр тус тус илүү илэрхийлэгдсэн бөгөөд татварын зардал/өглөгт нөлөөлнө/	1	4,004,324.2	1	4,004,324.2	-	-	1	4,004,324.2	-	-	-	-
2023 оны 6-р сард Сидар ХХК-д борлуулсан 270 тн шатахууныг өртгөөс 17.0 сая (НӨАТ-гүй) төгрөгөөр бага үнээр буюу алдагдалтайгаар борлуулсан байна.	1	18,721.5	1	18,721.5	-	-	1	18,721.5	-	-	-	-
Компани 2.1 сая төгрөгийн хөрөнгийн шинжтэй зүйлсийг зардалд бүртгэсэн.	1	2,101.9	-	-	1	2,101.9	1	2,101.9	-	-	-	-
Аудитын явцад залруулсан ажил гүйлгээний нөлөөллөөр татварын өр буурсан.	1	958,000.2	-	-	1	958,000.2	1	958,000.2	-	-	-	-

Эрдэнэс алт ресурс ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2003057 /Тоос цуглуулагч/ Лаборатори/ хөрөнгөд анхны өртгөөс давсан буюу илүү элэгдэл бодогдсон байна.	1	155.6	-	-	1	155.6	1	155.6	-	-	-	-
Өмнөх тайлант хугацаанд хамааралтай нягтлан бодох бүртгэлд алдаатай тусгагдсан байсан 41.3 сая төгрөгийн зардлыг 2023 онд нөхөж тусгаж залруулахдаа тайлант хугацааны зардлаар бүртгэсэн	1	41,302.7	-	-	1	41,302.7	1	41,302.7	-	-	-	-
Дараагийн тайлант оны зардалд хамаарах урьдчилж төлсөн түрээс, программ хангамжийн ашиглалтын төлбөр, бараа ажил үйлчилгээний урьдчилгаа төлбөр болох нийт 75.3 сая төгрөгийн зардлыг аккруэл сууриар бүртгээгүй, тайлант хугацааны зардлаар бүртгэсэн байна.	1	58,820.0	-	-	1	58,820.0	1	58,820.0	-	-	-	-
ЭАР ХХК-ийн бүртгэлд байгаа Өвөр монголын Жүй Ин худалдааны компаниас орсон урьдчилж орсон орлого аудитын тулган баталгаажуулалтын дүнгээс 5,081.49 ам.доллар илүү илэрхийлэгдсэн байна.	1	17,508.3	-	-	1	17,508.3	-	-	1	17,508.3	1	17,508.3
<b>Дүн</b>	<b>11</b>	<b>5,640,090.5</b>	<b>4</b>	<b>4,162,201.8</b>	<b>7</b>	<b>1,477,888.7</b>	<b>10</b>	<b>5,622,582.2</b>	<b>1</b>	<b>17,508.3</b>	<b>1</b>	<b>17,508.3</b>

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Мөнгөн хөрөнгийн ажил гүйлгээг анхан шатны баримт руу тулган шалгахад 9.3 сая төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ийн төлбөрийн баримт гаргуулан аваагүй байна	1	9,372.0	-	-	-	-	1	9,372.0	-	-	-	-
Үйлдвэрлэлийн шат дамжлага бүрт өртөг хуримтлуулж бүртгэхтэй холбоотой хуваарилах зардлын суурь тодорхойлоогүй байна. Мөн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд	1	19,481.8	-	-	-	-	1	19,481.8	-	-	-	-

хамааралгүй зардлыг өртөгт хуримтлуулж бүртгэсэн. Тухайлбал харуул хамгаалалтын зардлыг зөвхөн хүдэр олборлолтын өртөгт бүрэн шингээсэн бол өмнөх аудитаар төлбөрийн актны мөнгө 10 сая төгрөг, хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 9.5 сая төгрөгийг өртөгт оруулсан, харуул хамгаалалтын зардлыг хуваарилаагүй зэрэг байна.												
Компанийн үйл ажиллагаанд ашиглахгүй байгаа 19 тээврийн хэрэгсэл үндсэн хөрөнгөөр бүртгэлтэй, үүнд тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн зорилгоор 278.4 сая төгрөгийн элэгдэл тооцсон байна.	1	278,373.7	-	-	-	-	1	278,373.7	-	-	-	-
ТБОНӨХБАҮХАТ хуулийн хэрэгжилтийг ханган, харьцуулалтын болон нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөлгүйгээр нийт 712,782.2 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг хувааж шууд гэрээ байгуулсан, мөн гэрээ байгуулалгүй шууд худалдан авалтыг хийсэн байна.	1	712,782.2	-	-	1	712,782.2	-	-	-	-	-	-
Бараа ажил үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор чанарын баталгааг 5 хувиар суутган тооцох тухай гэрээнд заасан боловч гурван харилцагчаас нийт 39.8 сая төгрөгийн баталгааг суутгаж тооцоог үүсгээгүй байна.	1	39,847.6	-	-	-	-	1	39,847.6	-	-	-	-
Өмнөх онд өгсөн НБББББ-тэй холбоотой 2 зөвлөмж, худалдан авах ажиллагаатай холбоотой 4 албан шаардлагын хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
Хурал уулзалт, зочин хүлээн авалтын зардалд 2.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1	2,517.2	1	2,517.2	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>1,062,374.5</b>	<b>1</b>	<b>2,517.2</b>	<b>2</b>	<b>712,782.2</b>	<b>4</b>	<b>347,075.1</b>	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
			Үүнээс			Зөвлөмж			
	Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Компанийн эзэмшилд байгаа бүх төрлийн авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг цэнхэр дэвсгэртэй дугаараар солиогүй байна.	1	-						1	-
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 74 удаагийн 111,479.0 сая төгрөгийн орлого, зарлагын мөнгөн гүйлгээг хугацаа хоцроосон, 5.0 сая төгрөгийн 1 зарлагын мөнгөн гүйлгээг алдаатай, 15,445.6 сая төгрөгийн 12 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	126,929,684.6			1	126,929,684.6			
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>126,932,201.8</b>	<b>1</b>	<b>2,517.2</b>	<b>1</b>	<b>126,929,684.6</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>